

## ЯПОНЫ СУДЛААЧ, ЦЭРГИЙН ХҮНИЙ ҮЛДЭЭСЭН ХХ ЗУУНЫ ЭХНИЙ АР МОНГОЛЫН ЗҮҮН ХЭСГИЙН ГАЗАРЗҮЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Фүтаки Хироши

1908 оны 6 дугаар сард Японы археологи, угсаатны зүйн судлалыг үндэслэгч хэмээгдэх Тории Рюүзоо (1870-1953) нь эхнэр Кимико (1881-1959), нэг настай охиныхоо хамт Гадаад монголын Сэцэн хан аймгийн хоёр хошуу буюу Дундад дахь баруун этгээдийн (Илдэн вангийн) хошуу болон Зүүн гарын өмнөд (Эрхэмсэг бэйсийн) хошуугаар аялсан юм. Тэд нарын аялалын тэмдэглэл Torii Ryuzou, *Mouko ryokou* (Монголын аялалын тэмдэглэл, 1911)<sup>1</sup> хийгээд Torii Kimiko, *Dozokugakujou yori mitaru Mouko* (Угсаатны зүйн үүднээс үзсэн Монгол, 1927)<sup>2</sup> хэмээх хоёр номд оржээ.

1912 онд Японы Цэргийн жанжин штабын “Зураг хэмжилтийн түр хэсэг” (*Rinji sokuryoubu*) Халхын зүүн хэсгээр явж зураг хэмжсэн байна. 1933 онд хэвлэгдсэн “цэргийн маш нууцын” тэмдэгтэй 1:100.000-ийн масштабын *Hosshosuumi* (Хошуу сүм) гэсэн гарчигтай газрын зураг нь Халхын зүүн хэсгийг хамрах бөгөөд “1912 онд зургийг хэмжив, 1913 онд хэвлэв, 1925 онд засав, 1933 онд дөрвөлжин шугамыг зурав” гэсэн тайлбартай байдаг билээ. (Хавсралтыг үз)

1914 оны 6 дугаар сард Гуандун мужийн захиргааны хуурай замын цэргийн хэлтэсийн (*Kantou totokufu rikugunbu*) ахмад Ямагата Хацүо (*Yamagata Hatsuo*, 1873- ?) нар цэргийн байр зүйн материал цуглуулахын тулд үхэр тэргээр Өвөр монголын Шилийн голын чуулганы Зүүн Үзэмчин хошуунаас Ар монголын Сэцэн хан аймгийн Зүүн гарын өмнөд (Эрхэмсэг бэйсийн) хошуу орж, Халхын голыг гаталж Хөлөнбуйрт нэвтрэх 4 өдрийн аялал хийжээ.

Энэхүү өгүүлэлд Японы судлаач, цэргийн хүний үлдээсэн Ар монголын зүүн хэсгийн газарзүйн мэдээллийг авч үзнэ.

Манж Чин улсын Бадруулт төрийн 33 дугаар он буюу 1907 оны үед “Шинэ засгийн бодлогын” хүрээнд Ар Өвөр монголын чуулган хошуудын газрын зургийг зуруулжээ. 3

<sup>1</sup> Тус зохиол 1975 онд хэвлэгдсэн бүрэн зохиолын түүврийн 9 дүгээр ботьд орсон боловч, энэхүү өгүүлэлд анхны хэвлэлээс иш татав. Харин тус өгүүллийн сүүлд хавсаргасан тэд нарын аялалын маршрутын зураг нь алдааг зассан бүрэн зохиолынхыг ашигласан болно.

<sup>2</sup> 1931 онд хэвлэгдсэн хоёрдахь хэвлэлийг хэрэглэв.

**Фүтаки Хироши**

Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль  
hfutaki@tufs.ac.jp

**Фүтаки Хироши, Камимүра Акира, Э.Равдан, Л.Чулуунбаатар**

Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд  
МУИС пресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, ISBN 978-99962-72-59-2

жилийн дараа буюу 1910 онд дахиад чуулган хошуудын зургийг үйлдсэн байна. Эдгээр газрын зураг нь Берлин дэх Герман улсын номын сан, Улаанбаатарын Монгол улсын үндэсний номын сан, Улсын төв архив зэрэгт хадгалагдаж байгаа тул японы эрдэмтэн, цэргийн хүний тэмдэглэн үлдээсэн мэдээлэлтэй харьцуулан үзэхийг зорив.

Тории Рюзоо, Кимико хоёр Өвөр монголын Зостын чуулганы Харчин баруун хошууны засаг Гүнсээнноровын урилгаар 1906 онд Харчинд очжээ. Тэд нар нэг жил сургуульд багшлахын зэрэгцээ монгол хэл сурч монголын зан заншилтай танилцаж хээрийн судалгаанд бэлтгэсэн аж. Тории Кимикогийн өмнө тэндэхийн эмэгтэйчүүдийн сургуульд япон хэл зааж байсан Кавахара (Ичижоо) Мисако (1870-1945) Зүүн монгол дахь Оросын үйл ажиллагааны тухай мэдээлэл цуглуулж байсан япон офицеруудийн хооронд холбоо барих үүргийг Японы цэргийнхний тусгай даалгавраар гүйцэтгэж байснаараа алдартай болно. Гүнсээнноров ван нэг хэсэг Японоос зээл авч, япон офицеруудтай хамт шинээр бий болсон Дундад Иргэн улсын эсрэг зэвсэгт бослого хийхээр төлөвлөж байсан бөгөөд Японтой дотно харилцаатай байсан билээ. Тории Рюзоо, Кимико хоёрыг Харчинд очиход Япон-Оросын дайн дууссан байсан тул тэд нарын үйл ажиллагаа японы бодлоготой шууд холбоогүй байсан бололтой.

Тэд нар 1908 оны 3 дугаар сарын 8-нд Өвөр монголын Улаанхадаас гарч Онниуд, Баарин, Архорчин, Баруун Үзэмчингээр дайрч, 5 дугаар сарын 23-нд Халхын Сэцэн хан аймгийн Дундад дахь баруун этгээдийн (Илдэн вангийн) хошуунд хүрчээ. Бадруулт төрийн 33 дугаар оны 12 сарын 29 буюу 1908 оны 2 сарын 1-нд Гадаад монголын төрийг засах явдлын яамнаас тэдэнд олгосон “хамгаалах тэмдэгт бичигт” Аохан, Онниуд, Баарин, Үзэмчин, Халх, Архорчин, Засагт, Жарууд, Түшээт, Дархан, Дөрвөд, Горлос, Жалайд, Хорчин зэрэг хошуудаар зорчино гэж тэмдэглэсэн<sup>3</sup> боловч энд дурдсан Халх нь Гадаад монголын Халх биш, Дотоод Монголын Зуу удын чуулганы Халх хошууг хэлж байгаа нь мэдээж юм. Тории Гадаад монголд орох зөвшөөрөлгүйгээр хил нэвтэрсэн гэсэн үг бөгөөд зарим түшмэл түүнийг мэдсэн боловч бараг саад хийгээгүй өнгөрөөжээ. Тэд нар голдуу морин тэргээр, заримдаа үхэр, тэмээн тэргээр явсан байна.

Торигийн Ар монголд орсон гол зорилго нь Ар Өвөр монголын байдлыг харьцуулахад оршиж байв. Зөвхөн Өвөр монголд амьдарч ирсэн Ториид Ар монголын хэл, заншил маш сонин санагдсан бололтой. Тэрбээр, Халх монголчууд монголын уламжлалт соёлыг сайн хадгалж чадсан гэж өндөр үнэлж “Монголчуудын жинхэнэ заншил нь зөвхөн Гадаад монголд л үлдсэн гэхэд хэтрүүлэг болохгүй”, “Халх монгол хэл нь бичгийн хэлэнд хамгийн ойрхон байдаг хийгээд монгол хэл аялгуунуудын дотор сонсоход хамгийн аятайхан”<sup>4</sup> гэж сэтгэгдлээ тэмдэглэжээ.

Тории Рюзоо, Кимико нар дараахи маршрутаар аялсан байна.

1908 оны

5 дугаар сарын 23: Баруун Үзэмчим хошуунаас Сэцэн хан аймгийн Дундад дахь баруун этгээдийн (Илдэн вангийн) хошуунд оров. *Boroganbororuchi* (Баруун боролж).

5 дугаар сарын 24: *Chugunbororuchi* (Зүүн боролж), *Hairasotai* (Хайлаастай).

5 дугаар сарын 25: *Bainuruchi* (Баян өлзий?), *Tsuruge hotoka* (? худаг).

5 дугаар сарын 26: *Нayaerishi* (? элс?), *Chintomunsomu* (Чандмань сүм).

5 дугаар сарын 27: (жүн вангийн суудаг газар), *Rassa* (?).

5 дугаар сарын 28: *Hotsuren hotoka* (? худаг), Илдэн вангийн хошууны тамгын газар, хийд.

5 дугаар сарын 29: Хошууны тамгын газар.

5 дугаар сарын 30: *Bainuruchi* (Баян өлзий?), *Oiruhan* (?), *Boiruburunbeer* (Буйр? ?).

5 дугаар сарын 31: *Yuyurunooru* (Буйр нуур), *Mandaraobo* (Мандал овоо).

<sup>3</sup> Тории Кимико-гийн номд хавсаргасан “хамгаалах тэмдэгт бичигийг” үз.

<sup>4</sup> Torii, p. 263.

6 дугаар сарын 1: *Chaganobo* (Цагаан овоо), Халхын сүмд ойрхон байдаг айл.

6 дугаар сарын 2: *Shonhotabuntorogai* (Шунх? таван толгой).

6 дугаар сарын 3: *Ihuborohansomu* (Их бурхан сүм)<sup>5</sup>, *Hojiruchiruku* (Хужир ?), *Chokusunburu* (Цог? сүмбэр).

6 дугаар сарын 4: *Hojiruoran* (Хужир ?), *Urutentoho* (? тохой?), *Sabarugannunooru* (Сувраган нуур). Сэцэн хан аймгийн Зүүн гарын өмнөд (Эрхэмсэг бэйсийн) хошуунд оров.

6 дугаар сарын 5: *Ujimuren* (Өлзий? мөрөн?), *Hururenkoro* (? гол?), *Dettaibaishin no oufu* (Дэд бэйсийн тамгын газар)<sup>6</sup>.

6 дугаар сарын 6: *Sharaoran* (Шар? ?), *Bainhooa* (Баян хоолой).

6 дугаар сарын 7: *Shachinkyakuta* (Сэцэн? ?), Зүүн Үзэмчин хошууны *Rooha* (?)-д хүрэв.

Торийн Өвөр монголын Баруун Үзэмчин хошуунаас Илдэн вангийн хошуу орж, тамгын газарт хоёр хоносны дараа Буйр нуур хүрч Халхын голын дагуу зүүн урагшаа явж Эрхэмсэг бэйсийн хошуунд орж Зүүн Үзэмчин рүү гарчээ. Элсэн манхтай тал голлосон харьцангуй чинээлэг Илдэн вангийн хошуу, ой мод ихтэй уулархаг ядуувтар Эрхэмсэг бэйсийн хошуу, ийм хоёр хошууны ялгааг Тории нарийн тэмдэглэсэн байдаг. Тэрбээр, Илдэн вангийн хошууны тамгын газарт байхдаа мэргэжлийн сийлбэрчний хийсэн модон сийлбэрүүдийг сонирхож Гадаад монголын өвөрмөц урлаг гэж өндөр үнэлж хэрэг болгон захиалга өгөөд аваад явжээ.<sup>7</sup> Тэр үед Халхын голын дагуу маш олон барга мал хариулж байсныг Тории дэлгэрэнгүй дурдаж бичсэн нь Халх Баргын харилцааг судлахад чухал материал болно.

Тории буддын шашны талаар төдий л анхаарал тавиагүй ч зарим хэсэгт үнэтэй мэдээлэл үлдээжээ. Илдэн вангийн хошууны тамгын газрын тухай Тории “Хошууны тамгын газар энэ хавьд хамгийн өндөр дэнжид оршдог. Вангийн суух гэр, тамгын газар, бурханы шашны сүм зэрэг нь бүгд энэхүү өндөрлөгт байдаг. Эндэхийн сүм нэг ёсны Гадаад монголын өөрийн гэсэн өвөрмөц хэв маягтай, тухайлбал Хятад, Төвдийн холимог хэв маягтай агаад олон лам хуврагтай.” “Тус тамгын газар нь Өвөр монголынхоос ялгаатай, вангийн суух газраас бусад нь монгол гэр байдаг.” гэх мэтээр өгүүлсэн байна.

Торийгийн энэхүү тэмдэглэл тэр үед Гадаад монголын төрийг засах явдлын яамны тушаалаар зурсан газрын зурагтай үндсэндээ тохирч буй. Үүнд 1907, 1910 оны үед үйлдсэн газрын зурагт төв дунд нь Баянтүмэн өлзийт овоог зурж уулын энгэрт “чуулганы дарга чин вангийн зэрэг төрийн жүн ван Доржпаламын тус сахих газар” гэж тэмдэглэж түүний доор баруун гараас зүүн тийш Соёлыг бадруулагч сүм, Ёрыг бадруулсан сүм, Хамгийг хамгаалагч сүм, ийм гурван сүмийг маш томоор зурсан байдаг.<sup>8</sup>

Дашрамд хэлэхэд, Монгол улсын үндэсний номын санд хадгалагдаж байгаа, 1900 онд зурсан, өмнө зүгийг дээшээ харуулсан газрын зурагт “чуулганы дарга жүн вангийн тус сахих албан газрыг” Баянтүмэн өлзийт овооны байдаг өндөрлөгт биш, түүнээс зүүн урагшаа нэлээд зайтай, Ёнгор ташгайн ойрхон газарт, Ёрыг бадруулсан сүмийг Халхын голын зүүн эрэг дээр тус тус зурсан байна.<sup>9</sup> Чин улсын үед зурсан газрын зурагт тамгын газар, сүм хийд

<sup>5</sup> Тории Кимико 6 дугаар сарын 2-ний өдрийн тэмдэглэлд Их бурхан сүмийн тухай бичсэн байна (р. 447). Энэ хэсгээс хойш Рюзоо, Кимико хоёрын тэмдэглэл зөрчилдөж байна.

<sup>6</sup> 1907, 1910 онд зурсан тус хошууны газрын зурагт хоёр гэр зурж “*alban-u gajar*” “*ded beyise-yin ger*” гэж тус тус тэмдэглэсэн байдаг.

<sup>7</sup> Тории Кимикогийн номын 1060-1061, 1078-1079 дүгээр хуудасны завсарт модон сийлбэрүүдийн фото зургийг оруулсан байна.

<sup>8</sup> *Karte des Banners des Dorjipalmu (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 775: [http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_Hs\\_or\\_0013](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_Hs_or_0013)

*Karte des Banners des Dorjipalmu (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 776:

[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_Hs\\_or\\_0147](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_Hs_or_0147)

<sup>9</sup> *Шадарт явах чуулганы дарга зургаан зэрэг нэмсэн зургаан зэрэг тэмдэглэсэн засаг төрийн жүн вангийн хошууны нутгийн газар орны зураг*, Монгол улсын үндэсний номын сан, 8770/96.

зэргийн байршилыг хэр зэрэг зөв тусгасан вэ гэсэн асуудал нэлээд будлиантай, цаашид нарийн судалгаа хийх шаардлагатай гэж бодож байна.

1904-1905 онд болсон Япон-Оросын дайны дараа, хоёр улс хэлэлцээрээрээ Монгол, Манжуурт өөрсдийн эрх ашгийн хүрээг хуваах болжээ. 1912 оны Япон-Оросын гуравдугаар хэлэлцээр (нууц гэрээ) нь Бээжингээр өнгөрөх уртрагаар Япон (мөн шугамын зүүн хэсэг), Оросын (мөн баруун хэсэг) хүч нөлөөний хүрээг тогтоосноороо алдартай юм. Энэхүү гэрээний үр дүнд Японы эрх хүчний хүрээ Дотоод монголын зүүн хэсэгт тогтоогдож, япончууд, ялангуяа цэргийнхний Гадаад монгол дахь үйл ажиллагаа нэлээд хязгаарлагдах болжээ.

Ийм нөхцөл дунд капитан Ямагата Хацүо нь цэргийн санхүүгийн мэргэжилтэй капитан Сүзүки Сэитароо, монгол орчуулагч, хятад зарцтай дөрвүүлээ 1914 оны 5, 6 дугаар сард үхэр тэргээр Өвөр монголын зүүн хэсгийн хошуунууд, Ар монголын Эрхэмсэг бэйсийн хошуугаар аялсан байна.

Цэргийн академийг 1900 онд төгссөн Ямагата Японы армийн дотор Хятадыг дагнан судалсан нэгэн агаад 1920-иод оны үед Юннан мужийн цэргийн ерөнхий командлагч Тан Жияо (*Tang Jiyao*)-гийн цэргийн зөвлөхөөр ажиллаж байжээ.

Ямагата нарын Монгол дахь шинжилгээ нь зам, ус хаагуур байдаг, эд бараа яаж гүйдэг, үнэ нь ямар байдаг, аль сүмд хичнээн лам суудаг, голыг хаагуур гатлаж болох, гүн нь хэдэн метр болох гэх мэт үндсэн мэдээллийг цуглуулах зорилготой байсан юм.

1915 онд хэвлэгдсэн *Higashi Mouko* (*Зүүн монгол*) гэсэн гарчигтай номд Ямагатагийн бичсэн<sup>10</sup> замын тэмдэглэл орсон бөгөөд тэр үеийн Халхын зүүн хэсгийн байдлыг харуулсан сонирхолтой материал болно.

Ямагата нарын маршрутыг доор үзүүлэв.

1914 оны

6 сарын 8: Зүүн Үзэмчин хошуунаас Сэцэн хан аймагт оров. *Yukuchuru somu* (Егүзэр? сүм).

6 сарын 9: *Kantengoro* (? гол), *Mogoitengoro* (Могойтын? гол), *Hebucheneera* (? айл), *Rossonneera* (? айл).

6 сарын 10: *Hosshosomu* (Хошуу сүм), *Harahengoro* (Халхын гол).

6 сарын 11: Халхын гол гаталж Барга руу оров.

Ямагата монгол хэлний мэдлэггүй байсан тул түүний тэмдэглэсэн газрын нэрийг сэргээх нь нэлээд төвөгтэй байдаг. Гадаад монголын талаархи түүний мэдлэг дутмаг байсан нь Сэцэн хан аймгийн Зүүн гарын өмнөд (Эрхэмсэг бэйсийн) хошуу бие даасан хошуу болохыг мэдэхгүй Дундад дахь баруун этгээдийн (Илдэн вангийн) хошууны хэсэг нь гэж ойлгож байсан явдлаас дор нь мэдэж болно.

Ямагатагийн тэмдэглэлийн дотор хоёр сүмийн тухай дурдсан хэсэг материалын хувьд үлэмж сонирхолтой. Тэд нар Ар монголд орсон анхны өдөр буюу 1914 оны 6 дугаар сарын 8-нд 30 гэр барилгатай, 150 лам хуврагтай *Yukuchurusomu* хэмээх том сүмд хоножээ. Дараагийн өдөр нь 10 гэр байшин, 50 ламтай *Hosshosomu* гэдэг сүмийн хажуугаар өнгөрсөн байна.

Тории Рюүзоо *Yukuchurusomu* хэмээхийг *Ihuramainsomu* (Их ламын сүм), *Hosshosomu* хэмээхийг *Yanbuinsomu* (Ямбын? сүм) гэж тус тус нэрлэжээ.<sup>11</sup>

Ямагата болон Ториигийн аялалын үетэй ижил хугацаанд буюу 1907, 1910 оны үед зурсан бэйс Цэрэннэмын хошууны нутгийн зураг Берлин дэх Герман улсын номын санд хадгалагдаж буй. Тус газрын зурагт төв дунд нь Их амгалант сүм, түүний баруун талд нэгэн голын цаана Ерөөлийг илтгэгч сүмийг тус тус зурсан байна.

<sup>10</sup> Тус замын тэмдэглэлд Ямагата Хацүо, Сүзүки Сэитароо хоёр зохиогчийн нэрийг тавьсан боловч, агуулгаас нь үзэхэд Ямагата дангаараа бичсэн нь илэрхий.

<sup>11</sup> Torii, pp. 330-331.

Хэд хэдэн мэдээг хураангуйлан дүгнэхэд, 1808 онд Номгон уулын өвөрт байгуулж Чин улсын хаанаас “Их амгалант” нэр шагнуулсан сүмийг<sup>12</sup> Ямагата *Yukuchurusomu* гэж бичиж, Тории үүнийг *Ihuramainsomu* (Их ламын сүм) гэж тэмдэглэсэн бололтой. Дээр дурдсан 1907, 1910 оны газрын зурагт энэхүү Их амгалант сүмийг яг оршдог газраас нь нэлээд зайтай газарт зурсныг хэрхэн ойлгох вэ гэсэн асуудал зүй ёсоор гарч ирнэ. Түүнийг тус хошууны шашин шүтлэгийн төв болсон сүм хийдийг газрын зургийн төв дунд бичдэг тэр үеийн газрын зураг зурах гол зарчмыг<sup>13</sup> баримтласнаар тайлбарлаж болно.

1875 онд Өлзий мөрөнд нэгэн сүм байгуулж Чин улсын хаанаас “Ерөөлийг илтгэгч” нэр шагнуулжээ.<sup>14</sup> Хошууны тамгын газраас ойрхон байсан тул энэхүү сүмийг Ямагата *Hosshosomu* (Хошуу сүм), Тории *Yanbuinsomu* (Ямбын? сүм) гэж тус тус тэмдэглэсэн болов уу гэж үзэж байна. Тус сүмийн байршилийг дээрхи Японд хэвлэгдсэн 1:100.000-гийн масштабын газрын зургаас мэдэж болно. Тэнд тэмдэглэгдсэн *Hosshosuumu*, Ямагатагийн тэмдэглэсэн *Hosshosomu* хоёр нэг байх ёстой.

Эдгээр хоёр сүмийн лам нарын суудаг газрыг банзаар барьсан, Өвөр монголд огт харагдахгүй маш өвөрмөц хэв маягтай гэж Тории, Ямагата хоёр онцлон тэмдэглэсэн байна.<sup>15</sup>

Дараагийн жил буюу 1915 онд хоёр сүмийн аль аль нь дээрэмчдийн дайралтаас болоод шатсан<sup>16</sup> тул Ямагатагийн үлдээсэн тэмдэглэл 1910-аад оны үеийн эдгээр сүмийн байдалтай танилцахад үнэтэй материал юм.

Ямагата дээрэмчдийн төвлөрсөн газар, түүний тоо хэмжээний тухай тодорхой тэмдэглэжээ. Тэр үед “дээрэмчид” Үзэмчин, Хуучид, Хишигтэн, Баарин, Архорчин, Зарууд зэрэг Дотоод монголын хошуудад булаан авах үйл ажиллагаа явуулж байжээ. Эд нарын ихэнхи нь 1913 онд Гадаад монголын цэрэг Шилийн Гол, Цахарт орж ирэхэд цэрэгт татагдсан өвөрмонголчууд бөгөөд тэд нар Ар монголын цэрэг нутагтаа буцсаны дараа амьдрах аргагүй болж бүлэглэн дээрэмдэж эхэлсэн ажээ.<sup>17</sup>

Найдан гүнгийн удирддаг 400-гаад дээрэмчид Их амгалант сүмээс баруун хойно 2 километр зайтай *Chorusuhowa* гэдэг газарт төвлөрч тэндээс бараг өдөр бүр хэд хэдээрээ сүм рүү ирж янз бүрийн юм булаадаг байв. *Chorusuhowa*-д хоёр орос худалдаачин майхан барьж бараа худалдаж, дээрэмчдийн авчирсан адуу малыг худалдан авч Хайларт аваачдаг байсан гэдэг.<sup>18</sup>

“Зураг хэмжилтийн түр хэсэг” (*Rinji sokuryoubu*)-ийн үйлдсэн “Хошуу сүмийн” газрын зураг нь богино хугацаагаар “нууц хэмжилтийн” аргаар хийсэн тул тийм нарийн хийж чадаагүй шиг байна. Мөн зурагт контур шугам зурж физик газар зүйн мэдээлэл нэлээд орсон боловч, тэмдэглэгдсэн газрын нэр нь зөвхөн, *Hosshosuumu* (Хошуу сүм), *Harahen gawa* (Халхын гол), *Moroke shoroo aira* (? Шороо? айл?), ийм гурван нэрээс хэтрэхгүй тул төдий л ашигтай газрын зураг болоогүй. *Harahen gawa* гэж тэмдэглэгдсэн гол нь Халхын голын салаа мөн хэдий ч уг нь Нөмрөг гол гэж нэрлэдэг тул энэхүү газрын зургийг зөв

<sup>12</sup> Ч.Банзрагч, Б.Сайнхүү, *Монголын хүрээ хийдийн түүх (эмхтгэл)*, Улаанбаатар, 2004, pp. 87, 307. 1907, 1910 онд зурсан газрын зурагт *Yeke amugulangtu süm-e* гэж бичсэн байна.

*Karte des Banners des Ceringnima (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 777: [http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0097](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0097)

*Karte des Banners des Ceringnima (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 778: [http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0156](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0156)

Дашрамд хэлэхэд, Монголын сүм хийдийг бүртгэсэн С.Цэдэндамба, *Монголын сүм хийдийн түүхэн товчоон* (Улаанбаатар, 2009) номд оруулсан Дорнод аймгийн газрын зурагт тус сүмийн байршилыг үзүүлээгүй байна.

<sup>13</sup> Kamimura Akira, “A preliminary analysis of old Mongolian manuscript maps: towards an understanding of the Mongols’ perception of the landscape,” *Landscapes Reflected in Old Mongolian Maps*, edited by Futaki Hiroshi and Kamimura Akira, Tokyo, 2005, p. 19.

<sup>14</sup> Ч.Банзрагч, Б.Сайнхүү, pp. 87, 307. 1907, 1910 онд зурсан газрын зурагт *Yerügel-i iledkegci süm-e* гэж тэмдэглэсэн байна.

<sup>15</sup> Torii, p. 331. Yamagata, Suzuki, pp. 398-399.

<sup>16</sup> Ч.Банзрагч, Б.Сайнхүү, pp. 87, 307.

<sup>17</sup> Yamagata, Suzuki, pp. 397-398.

<sup>18</sup> *Ibid.*, pp. 396-397.

зохистой хөтөлсөн гэж үзэхэд төвөгтэй.

Японы цэргийн жанжин штабын үйлдэн хэвлүүлсэн цэргийн зориулалттай газрын зураг, Манж Чин улсын үед хошууны тамгын газраас эрхлэн зуруулсан газрын зураг хоёрыг харьцуулан үзэхэд, сүүлчийнх нь газрын хэмжээг яг зөв тусгаагүй ч гэсэн газрын нэр, гадаргын байдал төрхийг нь илүү нарийн тэмдэглэснээрээ өөрийн гэсэн үнэ цэнэтэй.

1910-аад оны үед Оросын тал мөн л цэргийн зорилгоор Монголын газрын зургийг үйлдэж эхэлсэн юм. Цэргийн төлөвлөгөө боловсруулахад газрын зургийг үйлдэх нь маш чухал үндсэн ажил болдог нь мэдээжийн хэрэг. Гараараа зурах уламжлалт газрын зургийн оронд шинээр нэвтэрсэн, орчин үеийн газар хэмжилтийн аргаар зурж хэвлэсэн газрын зураг нь цэргийн зориулалттай байсан гэдгийг Монголын газрын зургийн түүхийг судлахад ямагт анхаарах хэрэгтэй.

Энэхүү өгүүлэлд авч үзсэн Халхын зүүн хэсэг нь Японы хүч нөлөөний хүрээнд орсон Өвөр монголтой хил залгадаг бөгөөд Япон, Зөвлөлт хоёр орны өрсөлдөөнөөс ширүүн тулалдаан үүссэн Халхын голын районыг хамарсан тул дайн гарсан шалтгааныг судлахад Тории, Ямагата нарын үлдээсэн мэдээлэл чухал материал болно гэж найдаж байна.

## НОМЗҮЙ

*Karte des Banners des Dorjipalmu (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 775:

[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0013](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0013)

*Karte des Banners des Dorjipalmu (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 776:

[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0147](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0147)

*Karte des Banners des Ceringnima (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 777:

[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0097](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0097)

*Karte des Banners des Ceringnima (Setsen Khan-Distrikt)*, Katalog Nr. 778:

[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0156](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0156)

Sanbouhonbu, *Hosshosuumu*, Tokyo, 1933.

*Шадарт явах чуулганы дарга зургаан зэрэг нэмсэн зургаан зэрэг тэмдэглэсэн засаг төрийн жүн вангийн хошууны нутгийн газар орны зураг*, Монгол улсын үндэсний номын сан, 8770/96.

Банзрагч Ч., Сайнхүү Б., *Монголын хүрээ хийдийн түүх (эмхтгэл)*, Улаанбаатар, 2004.

Kamimura Akira, "A preliminary analysis of old Mongolian manuscript maps: towards an understanding of the Mongols' perception of the landscape," *Landscapes Reflected in Old Mongolian Maps*, edited by Futaki Hiroshi and Kamimura Akira, Tokyo, 2005.


Torii Kimiko, *Dozokugakujou yori mitaru Mouko*, Tokyo, 1931.

Torii Ryuuzou, *Mouko ryokou*, Tokyo, 1911.


Torii Ryuuzou, *Torii Ryuuzou zenshuu*, Vol. 9, Tokyo, 1975.

Цэдэндамба С., *Монголын сүм хийдийн түүхэн товчоон*, Улаанбаатар, 2009.


Yamagata Hatsuo, Suzuki Seitarou, "Mouko juudan ryokouki," Kantoutotokufu Rikugunbu, *Higashi Mouko*, Tokyo, 1915.



Тории Рюүзоогийн маршрут



Karte des Banners des Ceringnima (Setsen Khan-Distrikt), Katalog Nr. 777:  
[http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III\\_E\\_Hs\\_or\\_0097](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-III_E_Hs_or_0097)




Ямагата нарын маршрут





Японы цэргийн жанжин штабын хэвлүүлсэн хошуу сүмийн зураг



Karte des Banners des Dorjipalmu (Setsen Khan-Distrikt) , Katalog Nr. 775: [http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-IIIIE\\_Hs\\_or\\_0013](http://crossasia.org/digital/mongolische-karten/index/imgview/img/SBB-IIIIE_Hs_or_0013)